

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит бус хурлын тэмдэглэл

2022.08.30

Улаанбаатар хот

“Фронтиер Лэнд Групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 08 сарын 30-ны өдөр 12:00 цагт Пума Имperiал зочид буудлын хурлын бага танхимд эхлэв. Хуралд ирсэн Хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авав.

Тооллогын комиссын дарга Э.Пүрэвдулам, А. Амирлан

Нийт хувьцааны 80,56%-ийг эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигчидийн санал нь 7 454 666 хувьцаа буюу 100%-ийн санал хүчинтэйд тооцсон тул хурлын ирцийг хүчин төгөлдөр тооцсон тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулсан.

Хурлын дарга Э.Тэмүүлн

ТУЗ-ын дарга Э.Тэмүүлн хурлыг нээж хурлын дэгийг танилцуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

- ✓ ТУЗ -ийн гишүүд сонгох
- ✓ Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинчилсэн найруулгыг батлах /
- ✓ Бусад (Халаасны хувьцааг нийтэд болон гуравдагч этгээдэд худалдан борлуулах, энэхүү эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох)

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Компани одоо ямар үйл ажиллагаа эрхэлж байгаа вэ?

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгч Алишер Аманович

Өмнө нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулатын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан. Одоо энэхүү үйл ажиллагаа нь зогсонг талруугаа орсон учир энэ оны 3,4-р улиралаас эхлээд компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөр болгох тал дээр хамтар ч ажиллаж байна. Дэлхий даяр цахим үйл ажиллагаа руу шилжиж байгаатай холбоотой цахимжуулалт, технологтой холбоотой бизнессрүү үйл ажиллагаа явуулах чиглэлтэй байгаа.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Өмнө Туул Сонгино Усны Нөөцтэй холбоотой төсөл явж байсан билүү ?

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгч Алишер Аманович

2008 оноос энэ компанийг байгуулаад явж байсан. Одоо дийлэнх хувийн хөрөнгө оруулагч хэвээр байгаа. Дэд бүтцийн асуудлаас болоод төслийг явуулах боломжгүй болсон учраас зогсонги байдалтай байгаа. Одооноос үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх чиглэлтэй байна.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Ус цэвэршүүлэх асуудалтай холбоо хамааралгүй юу?

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгч Алишер Аманович

Мянганы солитын сангийн төслийн талаар та сая ярилаа. Америкийн засгийн газраас санхүүжигдээд эхлэх гэж байгаа Улаанбаатар хотын ундны усны төсөлтэй “Фронтиер Лэнд Групп” ХК холбоо хамаарал байхгүй. Туул Сонгино Усны Нөөц төслийг санаачилсан Ганбат захиралтай Морьт Импекс компани анх энэ төслийг санал болгоход нь “Фронтиер Лэнд” компани хөрөнгө оруулсан. Морьт Импекс компанитай хамтран ажиллах гэрээ байгуулаад төслийг урьдчилсан байдлаар бэлтгэх ажил, зардалд компани хөрөнгө оруулж санхүүжүүлсэн. 100, 200 сая доллараар яригдах том төсөл. Морьт Импекс компани энэхүү санхүүжилтээ өөрөө босгоод “Фронтиер Лэнд Групп” ХК-д энэхүү мөнгөө буцааж өгөх гэрээтэй. Гэтэл одоо болтол Ганбат захиралтай Морьт Импекс компани “Фронтиер Лэнд Групп” ХК-ийн хөрөнгө оруулалтыг буцааж өгөөгүй маргаантай нөхцөл байдал үүсцэн яваад байгаа.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Асуултанд хариулсанд баярлалаа.

Хурлын дарга Э.Тэмүүлн

Өнөөдрийн хэлэлцэх асуудлын жагсаалттай холбоотой өөр асуух зүйл байгаа юу?

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Байхгүй

Хурлын дарга Э.Тэмүүлн

“Фронттиер Лэнд Групп” ХК-ний төлөөлөн удирдах зөвлөлд хоёр шинэ гишүүн санал болгож байгаа. Үлдсэн 7 гишүүн дахин сонгогдож байгаа. Шинээр сонгогдож байгаа хараат бус 2 гишүүнд Сэр-Од, Толен гэдэг 2 хүнийг нэр дэвшүүлж байгаа. ТУЗ-д нэр дэвшиж байгаа шинэ 2 гишүүн, үлдсэн 7 гишүүнийг дахин томилох дээр санал хурааа.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Шинээр томилогдож байгаа 2 гишүүн байгаа юу? Энэ 2 гишүүний талаар мэдээлэл өгнө үү?

Хурлын дарга Э.Тэмүүлн

Толон Казахстан улсын иргэн. Монголд хувийн бизнес эрхэлдэг. Сэр-Од монгол улсын иргэн. Монголд бизнес эрхэлдэг.

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Ямар 2 гишүүний оронд сонгогдож байгаа вэ?

Хурлын дарга Э.Тэмүүлн

Оюунболд, Амартүвшин 2-ын оронд сонгогдож байгаа. ТУЗ-ын гишүүдийг сонгох дээр санал хураацгаая.

Тоологын комиссын дарга Э.Пүрэвдулам, Тооллогын комиссын гишүүн А.Амирлан
ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураах хуудсыг тоолсон дүнг танилцуулсан. Тус асуудал 100%-ийн саналаар дэмжигдсэн.

Хурлын дарга Э.Тэмүүлн

Компаний оноосон нэрийг Ди Жи фин болгон өөрчлөх, компаний нэр өөрчлөхтэй холбогдуулан компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт орно. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах дээр санал хурааа

Тоологын комиссын дарга Э.Пүрэвдулам, Тооллогын комиссын гишүүн А.Амирлан
Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах санал хураах хуудсыг тоолсон дүнг танилцуулсан. Тус асуудал 100%-ийн саналаар дэмжигдсэн.

Хурлын дарга Э.Тэмүүлн

Хэлэлцэх асуудлын бусад хэсэгт (Халаасны хувьцааг нийтэд болон гуравдагч этгээдэд худалдан борлуулах, энэхүү эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох) хувьцаа эзэмшигчдийн зүгээс компаны 4,497,462 ширхэг халаасны хувьцааг нийтэд болон гуравдагч этгээдэд худалдан борлуулах, энэхүү эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох асуудал дээр санал хурааа. Энэ асуудал дээр асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг

Хувьцааны зах зээлийн ханш хэдэн төгрөг байгаа вэ?

Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгч Алишер Аманович

Компанийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байсан учраас үнийн айхтар хөдөлгөөн ажиглагдаагүй. Үнэ зах зээлийн эрэлт нийлүүлэлтээсээ хамаарна. Сүүлийн 52 долоо хоног, нэг жилийн дундаж ханш 300-400 төгрөгийн хооронд байсан. Одоогийн зах зээлийн үнэ ханш 200 төгрөг байна. Одоогийн үйл ажиллагаагаа цахим санхүүгийн чиглэлрүү явуулж байгаа учраас эерэг нөлөө үзүүлж үйл ажиллагаа идвэхжсэнээр цаашид хувьцааны үнэ өснө гэж найдаж байгаа.

Тоологын комиссын дарга Э.Пүрэвдулам, Тооллогын комиссын гишүүн А.Амирлан
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын бусад хэсэгт хувьцаа эзэмшигчдийн зүгээс компаны 4,497,462 ширхэг халаасны хувьцааг нийтэд болон гуравдагч этгээдэд худалдан борлуулах, энэхүү эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох асуудал дээр санал хураасан дүнг танилцуулсан. Зөвшөөрсөн 7 454 666 ширхэг хувьцаа буюу Тус асуудал 100%-ийн саналаар дэмжигдлээ.

Хурлын дарга Э.Тэмүүлин

Хурлын дарга Хурлаас гарсан шийдвэр тогтоолыг уншиж танилцуулсан.

Хурлын дарга Э.Тэмүүлин хурлыг хаав.

Хурал: 13 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн У.Анар

Хянасан:

Хурлын дарга Э.Тэмүүлин

